

## **2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан мэдээлэл**

### **1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл**

Хөнгөн Бетон ХК нь барилгын ханын дулаан тусгаарлах шохойн блок хийдэг бөгөөд 50 гаруй жил үйл ажиллагаа явуулж байгаа юм. Өнгөрсөн 5 жилийн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан компанийн үйл ажиллагаа асар их доголдолд орсон тул компанийн орлого нэмэгдүүлэх зорилгоор компанийн үл хөдлөх хөрөнгийг бүхэлд нь түрээсэлсэн. Түрээслэгч тал өөр чиглэлийн үйл ажиллагаа явуулж байсантай холбоотойгоор компанийн зүгээс блок үйлдвэрлэн түрээсийн төлбөрт хөнгөлөлт үзүүлэн өөрсдөө үйлдвэрлэлээ явуулсан боловч татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр зэрэг байгууллагуудын өр төлбөрийн асуудлаас болж хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болон өр төлбөр улам нэмэгдсэн. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж асар хуучирсан учир засварын зардал болон сул зогсолт байнга үүссэн нь хэрэглэгчдийг найдвартай хангах тал дээр асуудал үүссэн. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өөрийн өртөг эдгээр шалтгаануудаас болж өссөн байна. Мөн хэрэглэгчид түлхүү МАК-ийн блокийг түлхүү хэрэглэж байгаа нь хэрэглэгчидийг хадгалж үлдэхэд хүнд байна. Түрээслэгч компани нэмэр болж борлуулалт олж ирсэн ч бартераар үйлдвэрлэл яюуулах тун хэцүү байсан. Түрээсийн орлогоор өр төлбөрийг төлж байгаа хэдий ч цалин хугацаандаа тавиагүйгээс болж үндсэн ажилчид тогтвортой ажиллахад хүндрэлтэй байлаа. Түрээслэгч байгууллага 2018 онд үйл ажиллагаагаа өргөтгөн явуулж эхэлсэн нь таатай байна. Энэхүү тогтмол орлогоороо өр төлбөрөө барагдуулах нь бэлэн мөнгө хомсдолтой үед их нэмэртэй байлаа.

### **2. Удирдлагын талаарх мэдээлэл**

Компанийн шинэ удирдлага нь дээрх хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас компанийг хэвийн авч явахад хүндрэлтэй байсан ба санхүүгийн тайлан балансыг гадны байгууллагаар хийлгэж ирсэн. Хүний нөөцийг аль болох зардал бууруулахын тулд хорих ангийн хүмүүжигч нар авч ажиллуулсан бөгөөд гэнэт хүмүүсээ татан авах зэрэг хүндрэлүүд гарч байсан. Компани ерөнхийдөө маш жижиг бүтэцээр буюу гэрээт гадны байгууллагын ажилчдаар үйлдвэрлэлийг явуулсан.

### **3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл**

Компани 2018 онд 635,9 сая төгрөгийн үнэ бүхий 4860м<sup>3</sup> бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бөгөөд дийлэнх борлуулалт бартер байсан ба түүхий эд материал ашиглалтын зардалыг бартераар төлөхөд хүнд байсан. Авлагатай хувь хүн компаниуд тэдгээрийн шүүхийн шийдвэрийн өр төлбөрт бартерийн хөрөнгүүдийг суутган тооцсон боловч үйлдвэрлэл явуулахын тулд төлөлт хийхийн тулд мөнгө зээлсэн зэрэг нь авлагыг өмнөх оноос 48,79 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. 2018 оны 4 сард банктай дахин хэлцэл байгуулж хугацааг дахин 5 жилээр сунгаж төгрөгийн хүүг 12 хувь байхаар тохиролцон өмнөх хүүгийн төлөлтөөс 600 сая төгрөг бууруулсан боловч ханшын зөрүүнээс болоод төгрөгт шилжсэн зээлийн дүн өмнө оноос 1,1 тэрбум төгрөгөөр өссөн байна. 2019 оны 4 сараас эхлэн үндсэн зээлийн төлөлт сар бүр төлөгдөх ба одоогоор оны эцсийн зээлийн хүүгийн үлдэгдэл 329,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### 4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

“Хөнгөн бетон” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 179,373 ширхэг. 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн 5 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн судалгаагаар дараах байдлаар хувьцаа эзэмшиж байна.

Д/д	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Тоо ширхэг	Хувь
1	Б.Наранзул	57,399	31,99%
2	Н.Эрдэмбилэг	53,842	30,01%
3	Б.Наранцацралт	26,655	14,86%
4	Н.Эрдэмбаяр	23,306	12,99%
5	“Минжит булган гол” ХХК	14,918	8,31%
		<b>176,120</b>	<b>98,18%</b>

#### 5. Ногдол ашгийн талаарх мэдээлэл

- 1) “Хөнгөн бетон” ХК болон “Хас банк” ХХК-ийн хооронд 2012 оны 11-р сард байгуулагдсан “Хугацаат зээлийн гэрээ”-ний “Зээлдэгч нь аливаа ногдол ашиг зарлахгүй, олгохгүй” тухай “Хавсралт 3 В.1” дүгээр заалтыг үндэслэн ногдол ашиг олгохгүй байгаа.
- 2) “Хөнгөн бетон” ХК нь 2018 онд алдагдалтай ажилласан ба банкны өмнө хүлээсэн үүргийн дагуу ногдол ашиг хуваарилах боломжгүй.

#### 6. Бусад шаардлагатай мэдээлэл

Гол түүхий эд нийлүүлэгч компанид олон жилийн өглөгийг хөрөнгө шилжүүлэхээр шүүхийн явцад эвлэрсэн. Одоогоор шилжүүлж чадаагүй байгаа бөгөөд газар нь банкны барьцаанд байгаа юм. Түрээсийн гэрээ нь их хэмжээний хэлцэлд тооцогдох ба жил бүр гэрээг дүгнэн явж байна. 2019 оноос компани бүхэлдээ зогсож зөвхөн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Д.БОЛОР

